



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/46

Хөхөө

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хүүхдийн эрхийн тухай 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит бус XXIV хуралдааны 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих 2024 оны нэрлэсэн жилийн ажлыг эрчимжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Баасанжав (Засаг даргын Тамгын газрын дарга)

Ажлын хэсгийн орлогч дарга: А.Отгонбаяр (Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

Ажлын хэсгийн гишүүд: Д.Оюунчимэг (Соёлын төвийн дарга)

Б.Өлзий (Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)

Ц.Цэрэнчимэд (Эрүүл мэндийн төвийн дарга)

З.Ариунзаяа (Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

П.Отгонбаяр (Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сургалтын менежер)

С.Эрдэнэчимэг (Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сургалтын менежер)

Д.Цэнд-Аюуш (Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын арга зүйч)

Х.Энхтүвшин (Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан)

Ч.Нарангэрэл (Нийгмийн эрүүл мэндийн ажилтан)

Д.Оюунсүрэн (Ерөнхий боловсролын сургуулийн
сэтгэл зүйч)

Б.Энхтунгалаг (Ерөнхий боловсролын сургуулийн
насан туршийн боловсролын багш)

Ч.Батцэцэг (Соёлын төвийн хөгжмийн багш)

М.Буяннэмэх (Сумын хэсгийн төлөөлөгч)

Г.Бямбадорж (Хэсгийн цагдаа)

Л. Энхтуяа (Ахмадын хорооны дарга)

Нарийн бичгийн дарга: Т.Алтанчимэг (Сумын нийгмийн бодлогын
мэргэжилтэн)

2.Нэрлэсэн жилийн хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжүүлэх бодлогын зорилт дэвшүүлж арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж, байгууллагуудыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, үр дүнг 2024 оны 04 дүгээр улиралд тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Баасанжав), ажлын хэсгийн орлогч дарга (А.Отгонбаяр), ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Т.Алтанчимэг) нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын засаг даргын тамгын газрын хууль эрх зүйн мэргэжилтэн (Б.Баярцэцэг)-д даалгасугай.

ДАРГА

Л.ЭНХЖАРГАЛ

